



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

「 Аудитын тайлан баталгаажуулах тухай 」

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/ нарт зөвлөсүгэй.
4. Аудитын тайлан, ажлын баримтыг 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын архивд шилжүүлж, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар /С.Энхбаатар/-т даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч /С.Оюунбилэг/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

НАГ-ын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор
С.Энхбаатар

Аудитын менежер
Х.Болдбаатар

Ахлах аудитор
Д.Отгонбаяр

Аудитор
Ц.Цэрэннамжил
С.Сугармаа
Б.Уранчимэг

2018 оны 12 дугаар сар

Тайланг ҮАГ-ын веб
сайт-аас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
261729 дугаарын утас,
260949 дугаарын
факсаар
харилцана уу.

Хаяг:
Үндэсний аудитын
газар
Засгийн газрын 4
дүгээр
байр,
Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар 15160,
Монгол улс

Агуулга	3-4
Товчилсон үгийн жагсаалт	5
Аудит хийх үндэслэл.....	6
Аудитын зорилт.....	6
Аудитын хамрах хүрээ.....	6
Аудитын арга зүй.....	6-7
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт	7
Үндсэн мэдээлэл.....	8
БҮЛЭГ 1. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД ШДНЦХ-Т БҮРЭН ХАМРАГДСАН БОЛОВЧ, ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА.	
1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ТӨҮГ-ууд ШДНЦХ-т бүрэн хамрагдсан боловч хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.....	9-11
1.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллээ байгууллагын мэдээллийн самбартаа бүрэн байршуулах нийтлэг стандартыг гаргаж, мөрдүүлэх шаардлагатай байна.....	11-12
1.3. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	12-13
БҮЛЭГ.2 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.3, 3.1.4, 3.1.5 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДАСТ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА.	
2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад хамаарах аж ахуй нэгж, байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.....	14-17
2.2. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд ШДНЦХ-т бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.....	17-19
2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид ШДНЦХ-т бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.....	19-21
БҮЛЭГ 3. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	
3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хөндлөнгийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн хэвээр байна.....	22-24
3.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалтгүй байна.....	24



3.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалтгүй байна.....	24-25
3.4. Өмнөх аудитаудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт 43.7 хувь байна.....	25-26
Дүгнэлт.....	27
Зөвлөмж.....	28-29
Хавсралт-1	30
Хавсралт-2	31
Холбогдох байгууллагын санал.....	32
“Нээлттэй нийгэм форум” ТББ-ын хийсэн “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааны тайлан”	33-60



Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НАГ	Нийцлийн аудитын газар
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНӨОХК	Орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компани
СБД	Сүхбаатар дүүрэг
СЯ	Сангийн яам
ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



Аудит хийх үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоолын дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэнэ.Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2²-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³, 3.1.4⁴, 3.1.5⁵-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

Хамарсан хүрээ

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 дахь хэсэгт заасан төрийн байгууллага, ТӨҮГ-ыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2⁶-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын дүн мэдээнд үндэслэн түүвэрлэн 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан.

Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-3.1.5-д заасан байгууллага, албан тушаалтныг бүрэн хамруулсан бөгөөд 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д заасан байгууллага, албан тушаалтны шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлд “Нээлттэй нийгэм форум” ТББ-тай байгуулсан гэрээний дагуу судалгаа, дүн шинжилгээ хийлгэн дүнг аудитын тайланд нэгтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² төрийн өмчит үйлдвэрийн газар

³ Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани

⁴ Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага

⁵ Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч

⁶ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.



хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулганы дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.



Үндсэн мэдээлэл

Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлснээс хойш Төрийн аудитын байгууллага тус хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу хуулийн хэрэгжилтийн байдалд 2015, 2016 онуудад тус бүр 2 удаа, 2017 онд 1 удаа аудитыг гүйцэтгэж, тайланг Улсын Их Хуралд хүргүүлж, олон нийтэд мэдээлсэн.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааг 2018 оны 3 дугаар улирлын байдлаар улсын төсвийн ТЕЗ-д, тэдгээрийн харьяа байгууллагууд 86.7 хувь, Аймаг, нийслэлийн ТЕЗ, тэдгээрийн харьяа байгууллагууд 86.2 хувь хэрэгжүүлсэн байна.

Тус аудитаар улсын төсвийн 32 ТЕЗ, тэдгээрийн харьяа 869 байгууллага, Аймаг нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрийн харьяа 4079 байгууллага буюу нийт 4948 байгууллагаас 4584 байгууллагыг түүвэрт хамруулан, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь ШДНЦХ-т байршуулсан эсэхийг төсөв, санхүүгийн холбогдох баримт, нотлох зүйлстэй тулган шалгасан.

Сангийн яамнаас гаргуулсан мэдээллээр 2018 онд III улирлын байдлаар Иргэд, олон нийт ШДНЦХ-т 324,578 удаагийн хандалтаар 2,675,397 мэдээлэлтэй танилцаж, байгууллагуудын мэдээлэл байршуулах чиг үүрэг бүхий албан хаагчид 413,183 удаагийн хандалт хийж холбогдох мэдээллийг ШДНЦХ-т байршуулсан байна.

Энэ удаагийн аудитад олон нийтийн оролцоог хангаж, аудитыг ил тод гүйцэтгэх зорилгоор “Нээлттэй нийгэм форум” ТББ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд шинжээчээр оролцуулж, Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Иргэний танхимд аудитын тайлангийн төслийг хүргүүлж, санал авч тус тус хамтран ажилласан.

“Нээлттэй нийгэм форум” ТББ нь ажлын даалгаврын дагуу хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах байгууллагуудын ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж ирүүлсэн дүнг аудитын тайланд нэгтгэж, ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцаж, хяналтыг хэрэгжүүлсэн эсэхэд хийсэн судалгааны “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааны тайлан”-г аудитын тайланд хавсаргав.

Аудитын явцад залруулах боломжтой зөрчилд тухай бүр зөвлөмж өгч ажилласнаас гадна нийт **48** байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах, **519** байгууллагад зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.



БҮЛЭГ.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ХАМААРАХ БАЙГУУЛЛАГУУД ШДНЦХ-Т БҮРЭН ХАМРАГДСАН БОЛОВЧ, ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА.

1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ТӨҮГ-ууд ШДНЦХ-т бүрэн хамрагдсан боловч хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагуудын төсвийн удирдлагыг хэрэгжүүлсэн шийдвэр, үйл ажиллагааг ил тод мэдээлэх нийт 4948 цэс ШДНЦХ-т нээгдэж, хуульд заасан мэдээллүүдийг байршуулах эрх үүсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас өмнө гүйцэтгэсэн 5 удаагийн аудитаар хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагуудын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээлэл тус бүрээр гарч буй зөрчил, шалтгаан нөхцөлийг дурдаж, хэрэгжилтийн байдлыг дэлгэрэнгүй тайлагнаж хүргүүлсэн.

Энэ удаагийн аудитын төлөвлөгөөнд тусгасны дагуу ТЕЗ-даас хэрэгжүүлж буй дотоод хяналтын дүн мэдээнд үндэслэн тэдгээрийн харьяа байгууллагуудын 2017 оны III улирлаас 2018 оны III улирлыг дуусталх хугацааны ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хуулийн заалт бүрээр хэрэгжилтийн байдлыг нэгтгэн тайланд хавсаргав. (Хавсралт №1, №2)

Нэгтгэсэн дүнгээр хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах улсын төсвийн ТЕЗ-ийн харьяа 869 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 86.7 хувь, Аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-ийн харьяа 4079 байгууллагын хэрэгжилт 86.2 хувьтай байна.

Аудитын хамрах хугацаанд Улсын төсвийн ТЕЗ-ийн харьяа 869 байгууллагын мэдээлбэл зохих 19,986 мэдээллээс 1,548 мэдээллийг, Аймаг, нийслэлийн ТЕЗ-ийн харьяа 4079 байгууллагын мэдээлбэл зохих 93,817 мэдээллээс 5,495 мэдээлэл, нийт 113,803 мэдээлбэл зохих мэдээллээс 7,043 буюу 6.2 хувийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. (Хүснэгт 1-д үзүүлэв)

Хүснэгт-1:

Улсын төсвийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын ШДНЦХ-т мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байдал

ТЕЗ	Нийт ААНБ-ын тоо	Мэдээлбэл зохих мэдээллийн тоо	Хугацаа хоцорч мэдээлсэн тоо	Хувь
Улсын төсвийн ТЕЗ	869	19986	1548	7.7
Аймаг, нийслэлийн ТЕЗ	4079	93817	5495	5.9
Нийт	4948	113803	7043	6.2

Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Тус аудитаар улсын төсвийн 32 ТЕЗ, түүний харьяа 869 байгууллагаас 13 ТЕЗ болон тэдгээрийн харьяа 505 байгууллагыг түүвэрт хамруулан, хуульд заасан мэдээллийг ШДНЦХ-т иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн эсэхийг төсөв, санхүүгийн баримт, нотлох зүйлстэй тулган шалгасан.



Аудитын түүвэрт хамрагдсан Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагууд ШДНЦХ-т хуульд заасан дараах мэдээллийг дутуу мэдээлдэг нийтлэг зөрчлийг гаргасаар байна. Үүнд:

- Төсөв захирагчийн хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг дутуу мэдээлдэг;
- Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг дутуу мэдээлдэг;
- Зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийг хавсаргадаггүй.
- Тендерийн урилга огт мэдээлдэггүй;
- Тендерт шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг огт мэдээлдэггүй;
- Тендерт шалгараагүй оролцогчийн товч мэдээллийг дутуу мэдээлдэг;
- Аудитын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлдэггүй;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг бүрэн мэдээлдэггүй зэрэг болно.

Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчинг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл, Тогтвортой амьжиргаа-3 төсөл болон 3.1.2-т хамаарах Хадгаламжийн даатгалын корпораци, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл зэрэг байгууллагууд ШДНЦХ-т цэс нээгдсэн хэдий ч хуульд заасан мэдээллийг огт мэдээлдэггүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁷-д шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр болон 6.10-т зарлагын гүйлгээ бүрд мэдээлэх шийдвэрийг ШДНЦХ-ын холбогдох хэсэгт мэдээлдэггүй зөрчил хэвээр байна. Үүнд:

- ✚ Баян-Өлгий аймгийн хэмжээнд 3980.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг;
- ✚ Баянхонгор аймгийн хэмжээнд 259,6 сая төгрөгийн 183 тушаал, шийдвэрийг;
- ✚ Булган аймгийн хэмжээнд 390.28 сая төгрөгийн 192 шийдвэрийг;
- ✚ Говь-Алтай аймгийн хэмжээнд 1,902.6 сая төгрөгийн 1898 тушаал шийдвэрийг;
- ✚ Говьсүмбэр аймгийн хэмжээнд 340.5 сая төгрөгийн 341 тушаал, шийдвэрийг;
- ✚ Дундговь аймгийн хэмжээнд 2,321.3 сая төгрөгийн 805 тушаал, шийдвэрийг;
- ✚ Завхан аймгийн хэмжээнд 6,423.4 сая төгрөгийн 569 тушаал, шийдвэрийг;
- ✚ Төв аймгийн хэмжээнд 4,786.1 сая төгрөгийн 953 тушаал, шийдвэрийг;
- ✚ Хэнтий аймгийн хэмжээнд 689,2 сая төгрөгийн 573 тушаал, шийдвэрийг;
- ✚ ХХААХҮЯ-ны ТНБД-ын төсөв, мөнгө зарцуулсан 48 тушаалыг;
- ✚ ЖДҮХС-ийн захирлын төсөв, мөнгө зарцуулсан 15 тушаалыг;
- ✚ ТЭДС-ийн захирлын төсөв, мөнгө зарцуулсан 13 тушаалыг;
- ✚ МХС-ийн захирлын төсөв, мөнгө зарцуулсан 18 тушаалыг;
- ✚ БХТ-ийн захирлын төсөв, мөнгө зарцуулсан 80 гэрээг тус тус мэдээлээгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хувьд санхүүжүүлэгч байгууллагаас гүйцэтгэгч хуулийн этгээдэд зарим санхүүжилтийг шууд шилжүүлдгээс тухайн төсөл, хөтөлбөрийн төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээлэл бүрэн мэдээлэгдэхгүй байгаа нь хуулийн 4 дүгээр зүйлд заасан “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” зарчим хангагдахгүй байна.

⁷ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;



Дээрх төсөл, хөтөлбөрийн худалдан авах үйл ажиллагааг харъяалах ТЕЗ зохион байгуулж, бусад үйл ажиллагааг төсөл, хөтөлбөрийн нэгж хариуцдагаас хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т заасан тендерийн мэдээллийг ШДНЦХ-т мэдээлдэггүй байх зөрчил давтагдсаар байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.3-т Засгийн газрын тусгай сангийн *“төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал, эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ”* хуулийн үйлчлэлд хамаарах ерөнхий зохицуулалтыг тусгасан.

Гэтэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-д *“энэ хуулийн 5.4.2, 5.4.4, 5.4.6, 5.4.8, 5.4.12-5.4.14, 5.4.16, 5.4.20, 5.4.25, 5.4.30, 5.4.32, 5.4.33, 5.4.40, 5.4.41-т заасан тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт”*-ийн асуудлыг Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах тухайн асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн хэрэгжүүлдэг хэдий ч тус сангуудын үйл ажиллагааны ил тод байдал хангагдахгүй байна.

Иймд Засгийн газрын тусгай сангийн төсвөөс зээл, хөнгөлөлт, урамшуулал олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулан Шилэн дансны тухай хууль, журамд нэмж тусгах шаардлагатай.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т хамаарах улс, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, харъяалах дээд шатны байгууллагаас нь төсвийг чанарын болон тоон шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгээр нарийвчлан баталдаггүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийг төсвийн бусад байгууллагуудын нэгэн адил сар тутам гаргадаггүй тул ШДНЦХ-т оруулах мэдээлэл, түүний агуулгыг тэдгээрийн онцлогт нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй дээрх зөрчлүүдийг гаргаж төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаагүй хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах улс, орон нутгийн төсвийн ТЕЗ-ийн харъяа 519 байгууллагад зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах 48 албан шаардлагыг тус тус хүргүүлсэн.

1.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллээ байгууллагын мэдээллийн самбартаа бүрэн байршуулах нийтлэг стандартыг гаргаж, мөрдүүлэх шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтад хамаарах Аймаг, нийслэл дэх 22 ТЕЗ-дын харъяа 4079 байгууллагаас 4071 нь хуульд заасан холбогдох мэдээллээ мэдээллийн самбартаа байршуулж, дараах байгууллагууд байршуулаагүй нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Нийслэлийн Газрын алба, "Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж" ОНӨҮГ, ХУД-ийн ИТХ, ЧД-ийн ХАА, СБД-ын "Багахандгайт" ОНӨААТҮГ, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, ИТХ.

Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тодорхой тусгаагүйгээс Аймаг, нийслэл дэх



ТЕЗ-дын харъяа байгууллагууд мэдээллийн самбартаа сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт зэргийг байршуулж, худалдан авалтын төлөвлөгөө, тендерийн талаарх мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ зэргийг нийтлэг байдлаар мэдээлдэггүй зөрчил байна.

Мөн аудитад хамрагдсан байгууллагуудын мэдээллийн самбартаа байрлуулсан мэдээлэл нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д заасан холбогдох албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байх шаардлагыг хангаагүй хуулбар хувийг байршуулдаг нийтлэг зөрчлийг гаргаж байна.

Иймд Аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-ийн харъяа байгууллагууд мэдээллийн самбартаа байршуулах мэдээллийн стандартыг холбогдох хууль, журамд тодорхой тусгаж иргэд олон нийт баталгаажсан үнэн зөв, иж бүрэн мэдээлэлтэй танилцах боломжоор хангах шаардлагатай байна.

1.3. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁸, 6.4⁹-д заасан мэдээллийг ил тод мэдээлэхээс гадна дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлэх үүргийг хуулийн 6 дугаар зүйлийн 6.5¹⁰-д тусгасан бөгөөд аудитын хамрах хугацаанд ШДНЦХ-т мэдээлэл байршуулсан байдлыг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт-2:

Сангийн яамнаас ШДНЦХ-т байршуулах мэдээлэл

Мэдээлэх хугацаа	Мэдээллийн агуулга	Мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцролтын тоо
VII/15, I/15-ны улирал бүр	Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт	3	3	1
улирал бүр	Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээ	4	4	1
улирал бүр	Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл	4	4	1
сар бүрийн 15-ны дотор	Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	12	12	2
VIII/15-ны дотор	Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг	1	1	-
улирал бүр	Хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны талаарх мэдээлэл	4	4	1
7 хоног дотор	Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт	-	-	-
улирал бүр	Улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан тооцоо, судалгаа	4	4	1

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас

⁸ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

⁹ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

¹⁰ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:



Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу ШДНЦХ-ыг Сангийн яам эрхлэн хөтлөх үүрэгтэй.

Гэтэл ШДНЦХ-ны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс хуулийн 4 дүгээр зүйлд заасан *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх”* зарчим хэрэгжихгүйгээс гадна, дараах зөрчил, хүндрэлийг үүсгэж байна. Үүнд:

- ✚ Улс орон нутгийн ТЕЗ болон түүний шууд харъяаны аппарат нь ШДНЦХ-т тус бүртээ мэдээлэл байршуулах цэс үүсгэснээс 1 ТЕЗ-ийн төсөв зарцуулах үйл ажиллагааг 2 газарт давхар мэдээлэх хүндрэлийг үүсгэж ажлын ачаалал нэмсэн;
- ✚ ШДНЦХ-т тендерийн урилга байршуулах цэс үүсгээгүй орхигдуулсан;
- ✚ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд 6 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд жилд 26 удаа мэдээлэхээр тусгасан байхад ШДНЦХ-т 8-10 төрлийн мэдээллийг жилд 64-ээс дээш удаа мэдээлэх цэс үүсгэж ажлын ачаалал нэмсэн;
- ✚ Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчит хуулийн этгээд 9 төрлийн мэдээллийг шийдвэр гарснаас хойш тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан байхад ШДНЦХ-т 10 төрлийн мэдээллийг жилд 64 удаа, 8 төрлийн мэдээллийг тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэх цэс үүсгэж ажлын ачаалал нэмсэн;
- ✚ Байгууллагууд 10 сая төгрөгөөс дээш худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ШДНЦХ болон www.tender.gov.mn хаягаар давхар мэдээлдгээс ажлын ачаалал үүсгэж, мэдээлэл орхигддог байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн эсэхэд хөндлөнгийн хяналтын байгууллага болон иргэд олон нийт ШДНЦХ-аар хяналт тавих боломжгүйгээс Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”* зарчим хэрэгжихгүй байна.

Иймд ШДНЦХ-ийг дараах төсөв, санхүүгийн программ, системтэй уялдуулан мэдээллийг шууд хөрвүүлэн байршуулах боломжийг хангаж шинэчлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- ✚ Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа санхүүгийн программ;
- ✚ Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн систем;
- ✚ Төсвийн төлөвлөлтийн систем;
- ✚ Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем;
- ✚ Төсвийн хөрөнгө оруулалтын систем;
- ✚ Зээл тусламжийн систем;
- ✚ Худалдан авах ажиллагааны удирдлагын систем;
- ✚ Бусад.

ШДНЦХ-т мэдээлэл байршуулах загвар, стандартыг нарийвчлан зохицуулсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”*-ыг Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагад нийцүүлэн, энэхүү аудитын тайланд дурдсан асуудлыг тусгаж, шинэчлэн боловсруулах шаардлагатай.



БҮЛЭГ 2. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.3, 3.1.4, 3.1.5 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ШДНЦХ-Т ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН БАЙРШУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад хамаарах аж ахуй нэгж, байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанид хамаарах Төрийн өмчит ХК-46, Төрийн өмчит ХХК-19, Төрийн өмчийн оролцоотой ХК-6, Төрийн өмчийн оролцоотой ХХК-8, Хувь нийлүүлсэн нийгэмлэг-1 тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Тус компаниудын санхүүгийн тайлан дараах ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж байна. (Хүснэгт 3-д үзүүлэв)

Хүснэгт-3:

ТӨХК, ТӨХХК, ТӨОХК, ТӨОХХК, ХНН-ийн санхүүгийн тайлангийн харъяалах ТЕЗ

№	ТЕЗ-ИЙН НЭР	ТӨХК	ТӨХХК	ТӨОХК	ТӨОХХК	ХНН	НИЙТ
1	Зам тээвэр, хөгжлийн сайд	23	-	1	-	1	25
2	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	-	1	2	-	-	3
3	Сангийн сайд	2	4	-	-	-	6
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	-	11	3	8	-	22
5	Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	-	1	-	-	-	1
6	Эрчим хүчний сайд	21	2	-	-	-	23
	Нийт	46	19	6	8	1	80

Эх сурвалж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн мэдээлэл.

Дээрх заалтын хүрээнд хамаарах ОНӨХК-3, ОНӨХХК-20, ОНӨОХК-3, ОНӨОХХК-1 үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд харъяалах ТЕЗ-аар хүснэгт 4-д үзүүлбэл:

Хүснэгт-4:

ОНӨХК, ОНӨХХК, ОНӨОХК, ОНӨОХХК-ийн харъяалах ТЕЗ

№	ТЕЗ-ИЙН НЭР	ОНӨХК	ОНӨХХК	ОНӨОХК	ОНӨОХХК	НИЙТ
1	Архангай аймгийн Засаг дарга	-	1	-	-	1
2	Баянхонгор аймгийн Засаг дарга	1	2	-	-	3
3	Дархан-Уул аймгийн Засаг дарга	-	-	1	-	1
4	Дорноговь аймгийн Засаг дарга	-	4	-	-	4
5	Өвөрхангай аймгийн Засаг дарга	-	-	1	-	1
6	Өмнөговь аймгийн Засаг дарга	-	-	1	1	2
7	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	-	3	-	-	3
8	Хөвсгөл аймгийн Засаг дарга	2	10	-	-	12
	Нийт	3	20	3	1	27

Эх сурвалж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн мэдээлэл.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах байгууллагуудаас “Оюу толгой” ХХК болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болох “Эрдэнэс ашид” ХХК, “Эрдэнэс стийл” ХХК, “Эрдэнэс ассет менежмент” ХХК нь ШДНЦХ-т хамрагдаагүй байна.

Дээр дурдсан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 3 охин компанийн хувьд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч үйл ажиллагаа явуулж эхлээгүй байгаа тул



толгой компанид тус компаниудын үйл ажиллагааг эхлэх үеэс ШДНЦХ-т бүртгүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах зөвлөмж өгсөн.

ШДНЦХ-т бүртгэлтэй боловч мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хугацаанд мэдээлээгүй зөрчлийг гаргасан төрийн өмчит “Дархан дулаан шарын гол” ХК, “Дархан АЗЗА” ХК болон Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨХХК-д зөрчил арилгах албан шаардлага өгсөн.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах зарим байгууллагууд дараах зөрчлийг гаргасан нь мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1, 6.8.2-т заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчит “Тариалан НААҮТ” ХХК 79.9 сая төгрөгийн өрийн мэдээлэл болон тендер худалдан авалттай холбоотой 13 худалдан авалтын 277.2 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй;
 - Аймгийн орон нутгийн өмчит “Тосон-Илч” ХХК тендер худалдан авалттай холбоотой 109.5 сая төгрөгийн худалдан авалтыг;
 - Аймгийн орон нутгийн өмчит “Их-Уул Дулаан” ХХК тендер худалдан авалттай холбоотой 157.0 сая төгрөгийн худалдан авалтыг;
 - Аймгийн орон нутгийн өмчит “Хоймор нутгийн чулуу” ХХК сум хөгжүүлэх сангаас авсан 40.0 сая төгрөгийн өр, холбогдох шийдвэрийг тус тус мэдээлээгүй;
 - Аймгийн орон нутгийн өмчит “Шинэ-Мөрөн худалдааны төв” ХК шилэн дансанд бүртгэлтэй боловч холбогдох мэдээллийг огт мэдээлээгүй.
2. Архангай аймгийн орон нутгийн өмчит “Ундарга” ХХК засгийн газар, орон нутгийн баталгаа, Төрийн байгууллага, улсын төсөвтэй холбоотой үүссэн авлагын талаарх шийдвэр, мэдээллийг огт мэдээлээгүй зөрчлийг тус тус гаргасан байна.

Хуулийн дээрх заалтад хамаарах байгууллага, албан тушаалтан мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг байршуулах үүрэг хүлээсэн.

Гэвч хуулийн заалтад тусгагдсан зарим мэдээллийн төрөл нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 4 дүгээр зүйлийн 4.2 болон ШДНЦХ-ны 2 бүлэг, 7 хэсэг бүхий цэсэд дараах байдлаар зөрүүтэй тусгагдсан байдлыг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт-5:

Хууль, журам, ШДНЦХ тус бүрт зөрүүтэй байдлаар тусгасан мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн зохицуулалт		Журмын ¹¹ зохицуулалт		Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс
6.8.2	Тендерийн баримт бичиг, тендерийн урилга		Тендерийн баримт бичиг, тендерийн урилгыг мэдээлэх талаар зохицуулаагүй	Тендерийн баримт бичиг, тендерийн урилгыг мэдээлэх хэсэг үүсгээгүй
	Хуульд заагаагүй	4.2.3	Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, шийдвэрийг гарсан өдөр нь	Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг оруулах хэсэг үүсгэсэн.
	Хуульд заагаагүй		Журмаар зохицуулаагүй	Худалдан авах ажиллагааны тайлан оруулах хэсэг үүсгэсэн

Эх сурвалж: Шилэн дансны тухай хууль, журам, ШДНЦХ.

¹¹ МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”



Хүснэгтийн 2 дахь мөрөнд харуулснаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3¹²-т хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах байгууллагыг төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг ШДНЦХ-т мэдээлэх нэмэлт зохицуулалтыг тусган хуульд заагаагүй үүрэг хүлээлгэсэн байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.5-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7-д “Захиалагч худалдан авах ажиллагаа батлагдсан даруйд худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д оруулж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулж, батлуулна” гэж тус тус зааж, төлөвлөгөө батлах хугацааг тодорхой тусгаагүй байна.

Гэтэл хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэхээр заасан бөгөөд байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тус хугацааны дотор батлагдаагүйгээс ШДНЦХ-т хугацаа хоцорч мэдээлдэг зөрчил гарсаар байна. Иймд Шилэн дансны тухай хуульд заасан хугацааг ТБОНӨХБАҮХАТХ болон холбогдох журамд заасан хугацаатай уялдуулан өөрчлөх шаардлагатай.

Мөн Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т “Захиалагч тухайн жилийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг энэхүү журмын нэгдүгээр хавсралтын Маягт 1-ийн дагуу боловсруулах”-аар заасан.

Харин “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4.2.1-д худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу мэдээлэхээр заасан.

Дээрх 2 журмын маягтууд нь зөрүүтэй байгаагаас шилэн дансанд мэдээлэл байршуулж буй албан хаагчдад ачаалал үүсгэх, батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан мэдээлэл дутуу, зөрүүтэй мэдээлэгдэх зэрэг зөрчил үүсгэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Иймд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг (www.tender.gov.mn) цахим хаягаас татаж, шилэн дансанд мэдээлэх зохицуулалтыг журамд тусгаж, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “*тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ*”, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д “Гүйцэтгэх

¹² “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр ...”



удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж тус тус заасан байна.

Гэтэл Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах компаниудын ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулсан контракт, гэрээнд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар тодорхой заалт тусгаагүй байна.

Иймд хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн ТУЗ Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулахдаа Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар заалт тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэх шаардлагатай байна.

2.2. Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд ШДНЦХ-т бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.

“Нээлттэй нийгэм форум” ТББ-ыг Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитад шинжээчээр оролцуулж, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-т хамаарах ААНБ-ууд ШДНЦХ-т хамрагдсан эсэх, мэдээллээ бүрэн байршуулсан эсэхэд судалгаа хийлгэсэн.

Аудитын хамарсан хугацаанд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах улсын төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн нийт 941¹⁴ ААНБ-аас 4.8 хувь буюу 45¹⁵ байгууллага нь ШДНЦХ-т мэдээлэл байршуулах цэстэй бөгөөд үүнээс 2 ААНБ хуульд заасан мэдээллийг байршуулсан байна. Харин Үлдсэн 43 ААНБ нь ШДНЦХ-т мэдээлэл байршуулах цэс нээсэн боловч мэдээлбэл зохих мэдээллээ байршуулаагүй байна. ШДНЦХ-т хамрагдсан байдлыг зураглал 1-д харуулбал:

Цахим хуудаст бүртгэгдсэн байдал ¹³	
Бүртгэгдвэл зохих байгууллагын тоо	941
Бүртгэгдсэн байгууллагын тоо	45
Бүртгэгдсэн хувь	4.8%

¹³ Эх сурвалж ТЕЗ-даас ирүүлсэн мэдээлэл


¹⁴ Давхардсан тоогоор Зарим ААН, байгууллага 2017, 2018 онуудын ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн эсвэл хэд хэдэн ТЕЗ-аас ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн тохиолдолд гарсан

¹⁵ Давхардсан тоогоор Зарим ААН, байгууллага 2017, 2018 онуудын ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн эсвэл хэд хэдэн ТЕЗ-аас ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн тохиолдолд гарсан



Зураглал -1:

**Яамдын санхүүжилтээр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэж буй ААНБ-ууд
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдсан байдал:**



Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

ШДНЦХ-т цэс нээгдсэн нийт 941 ААНБ нь мэдээлбэл зохих нийт 449.9 тэрбум төгрөгийн 1142 мэдээллээс зөвхөн 2 ААНБ 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн мэдээллээ байршуулж, 99.8 хувь буюу 939 ААНБ мэдээлээгүй байна.Үүнд:

Санхүүжилтийн дүнг нийтэлсэн байдал	
Тайлагнавал зохих санхүүжилт	449.9 тэрбум төг
Тайлагнасан санхүүжилт	1.7 тэрбум төг
Тайлагнасан хувь	0.4%

- БСШУСЯ-аас ажил, үйлчилгээ авсан “Хатуу төмөр” ХХК-ын Архангай аймгийн Хашаат суманд хэрэгжиж буй нийт 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 250 суудал бүхий Соёлын төвийн барилгын төсөл;
- “Бор божуу” ХХК-ын Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр багт хэрэгжиж буй нийт 900 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга худалдан авах төслийн мэдээллийг санхүүжилтийн өссөн дүнгээр ШДНЦХ-т тус тус байршуулжээ.


Нийслэл болон дүүргүүдийн хэмжээнд улс, орон нутгийн төсвөөс 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэгч нийт 955¹⁶ ААНБ-аас зөвхөн 4.1 хувь буюу 39 ААНБ ШДНЦХ-т хамрагдсан байна. График 3-д үзүүлбэл:

¹⁶ Давхардсан тоогоор зарим ААНБ, байгууллага 2017, 2018 онуудын ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн эсвэл хэд хэдэн дүүрэгт ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн тохиолдолд гарсан.



Зураглал-3:

Нийслэл, дүүргүүдэд Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т хамаарах ААН, байгууллагууд ШДНЦХ-т хамрагдсан байдал



Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Нийслэл, дүүргийн нийт 955 ААНБ-ын байршуулбал зохих 2017 оны 149.9 тэрбум төгрөгийн 728, 2018 оны 119.9 тэрбум төгрөгийн 551 буюу нийт 269,8 тэрбум төгрөгийн 1279 мэдээллийг ШДНЦХ-т огт байршуулаагүй байна.

Дээрх зөрчил нь ШДНЦХ-т ААНБ-ын цэс үүсгэх, мэдээлэл байршуулах үүргийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай гэрээнд тусгадаггүй, санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх талаарх харилцааг хууль болон холбогдох журамд нарийвчлан зохицуулаагүйтэй холбоотой байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах ААНБ-тай төсөв захирагчид гэрээ байгуулахдаа шилэн дансанд цэс нээлгэх, мэдээлэл байршуулах үүрэг, хариуцлагын талаар тусгаж үр дүнг үнэлэх, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид ШДНЦХ-т бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Тухайн хэсгийн судалгааг “Нээлттэй нийгэм форум” ТТБ-аар гүйцэтгүүлсэн бөгөөд улсын төсвийн ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжээс аудитад хамрагдсан тэдгээрийн харъяа байгууллагууд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5¹⁷-д хамаарах иргэн, ААНБ-тай гэрээ байгуулаагүй гэсэн судалгааг ирүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн

¹⁷ төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.



хэрэгжилтийн байдлыг шалгах 2019 оны аудитаар тус мэдээллийг холбогдох баримт, нотлох зүйлсэд тулгуурлан дүгнэлт гаргана.

Нийслэл болон 9 дүүргийн ТЕЗ-д төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг 845 иргэн, ААНБ-аар гүйцэтгүүлэх гэрээ байгуулснаас 785 иргэн, ААНБ буюу 92.9 хувь нь ШДНЦХ-т хамрагдсан байна. Хүснэгт 6-д үзүүлбэл:

Хүснэгт-6:

ШДНЦХ-т хамрагдсан ААНБ-ын тоо

№	Дүүрэг	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд		
		Хамрагдах ААНБ-ын тоо	Хамрагдсан ААНБ-ын тоо	Хамрагдалт /дундаж хувь/
1	БГД	123	122	99.2
2	БЗД	341	322	94.4
3	СХД	97	90	92.8
4	СБД	114	94	82.5
5	ХУД	105	105	100.0
6	ЧД	51	47	92.2
7	БНД	1	1	100.0
8	НД	13	4	30.8
9	БХД	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага байхгүй гэсэн судалгааг ирүүлсэн.		
	Нийт	845	785	92.9

Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч дээрх 845 иргэн, ААНБ төсвөөс авсан санхүүжилтийн талаарх мэдээллээ улирал тутамд давхардсан тоогоор 2541 мэдээллийг ШДНЦХ-т мэдээлэхээс 2091 мэдээлэл буюу дунджаар 82.3-ийг нь мэдээлсэн байна. Хүснэгт 7-д үзүүлбэл:

Хүснэгт-7:

ШДНЦХ-т ААНБ-ууд мэдээлэл байршуулсан байдал

№	Дүүрэг	Байршуулбал зохих мэдээллийн тоо	Байршуулсан мэдээллийн тоо	Мэдээлсэн байдал /дундаж хувь/
1	БГД	466	461	98.9
2	БЗД	771	627	81.3
3	СХД	394	365	92.6
4	СБД	281	111	39.5
5	ХУД	382	375	98.2
6	ЧД	195	133	68.2
7	БНД	4	4	100.0
8	НД	48	15	31.3
	Нийт	2541	2091	82.3

Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Мэдээлэл байршуулсан байдлыг улирлаар авч үзвэл 2017 оны IV улиралд 83.2, 2018 оны I улиралд 83.5, II улиралд 82.6, III улиралд 80-тай буюу санхүүжилтийн мэдээллийг өссөн дүнгээр улирал тутам тайлагнаж мэдээлэх үйл явц бага зэрэг буурсан байна. Энэ нь зарим ААНБ тухайн ажил, үйлчилгээний санхүүжилтийн мэдээллийг I улиралд мэдээлээд, II ба III улирлуудад өссөн дүнгээр нь дахин мэдээлээгүйтэй холбоотой. Хүснэгт 8-д үзүүлбэл:



Хүснэгт-8:

ШДНЦХ-т ААНБ-ууд санхүүжилтийн мэдээллээ байршуулсан байдал

№	Дүүрэг	Санхүүжилтийн мэдээллээ мэдээлсэн байдал /хувиар/				Дундаж /дундаж хувь/
		2017 оны IV улирал	2018 оны I улирал	2018 оны II улирал	2018 оны III улирал	
1	БГД	99.1	99.2	99.2	98.3	98.9
2	БЗД	83.9	81.9	81.9	77.9	81.4
3	СХД	96.8	90.0	92.0	92.0	92.7
4	СБД	44.6	40.6	37.7	34.8	39.4
5	ХУД	89.6	100.0	100.0	100.0	97.4
6	ЧД	83.3	75.5	63.3	51.0	68.3
7	БНД	100.0	100.0	100.0	100.0	100.0
8	НД	25.0	33.3	33.3	33.3	31.3
	Нийт	83.2	83.5	82.6	80.0	82.3

Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Санхүүжилтийн мөнгөн дүнгээр авч үзвэл нийслэл, дүүргүүдийн хэмжээнд 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд зориулж төсвөөс 2017 онд 40,509.4 сая, 2018 оны III улирлын байдлаар 36,472.4 сая, нийт 76,981.8 сая төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэгч ААНБ-ууд 63,652.1 сая төгрөгийн санхүүжилтийг буюу дунджаар 82.7-ийг ШДНЦХ-т байршуулсан байна. Хүснэгт 9-д харуулбал:

Хүснэгт-9:

ШДНЦХ-т ААНБ-ууд санхүүжилтийн мэдээллээ байршуулсан байдал

№	Дүүрэг	Олгосон санхүүжилт /сая.төг/	Мэдээлсэн санхүүжилт /сая.төг/	Мэдээлсэн байдал /дундаж хувь/
1	БГД	11,704.8	11,672.7	99.7
2	БЗД	24,620.8	21,168.8	86.0
3	СХД	14,477.1	13,611.0	94.0
4	СБД	10,389.1	4,402.8	42.4
5	ХУД	7,290.4	6,934.2	95.1
6	ЧД	7,062.8	5,137.7	72.7
7	БНД	56.5	48.9	86.6
8	НД	1,380.3	676.0	49.0
	Нийт	76,981.8	63,652.1	82.7

Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

ШДНЦХ-т байршуулсан мэдээллийн хувьд зарим ААНБ тухайн байгууллагын тодруулга өгөх албан тушаалтны нэр, утсыг тодорхой бичээгүй, улирал тутмын мэдээллийг тогтмол байршуулаагүй, төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээний ерөнхий мэдээллийг маягтын дагуу тодорхой, бүрэн гүйцэд мэдээлээгүй зөрчил дутагдлууд ажиглагдаж байна.



БҮЛЭГ 3. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹⁸ дэх хэсэгт заасан бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал хөндлөнгийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн хэвээр байна.

а) Төрийн аудитын байгууллагаас 5 удаагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлж ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг ...төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан.

Шилэн дансны тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсанаас хойш Төрийн аудитын байгууллагаас 2015 онд 2 удаа, 2016 онд 2 удаа, 2017 онд 1 удаа тус тус нэгдсэн удирдамж¹⁹ бүхий аудит хийж, аудитын тайланг УИХ болон Засгийн газарт хүргүүлэн, Төрийн аудитын тухай хуульд заасан холбогдох арга хэмжээг авч, хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж байна.

б) Бүх шатны ИТХ, ИНХ хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал... хэрэгжүүлнэ” гэж заасан боловч чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Хүснэгт 10-д үзүүлбэл:

Хүснэгт-10:

Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, ИНХ-аас хяналтыг хэрэгжүүлсэн байдал

№	Аймаг, нийслэл	Хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлсэн эсэх		
		Аймаг, нийслэлийн ИТХ	Сум, дүүргийн ИТХ	Баг, хорооны ИНХ
1	Архангай	Тийм	Үгүй	Үгүй
2	Баян-Өлгий	Үгүй	Тийм	Үгүй
3	Баянхонгор	Тийм	Үгүй	Үгүй
4	Булган	Тийм	Тийм	Үгүй
5	Говь-Алтай	Үгүй	Үгүй	Үгүй
6	Говьсүмбэр	Үгүй	Үгүй	Үгүй
7	Дархан-Уул	Тийм	Тийм	Үгүй
8	Дорноговь	Тийм	Үгүй	Үгүй
9	Дорнод	Тийм	Үгүй	Үгүй
10	Дундговь	Үгүй	Үгүй	Үгүй
11	Завхан	Үгүй	Үгүй	Үгүй
12	Орхон	Тийм	Үгүй	Үгүй
13	Өвөрхангай	Тийм	Тийм	Үгүй
14	Өмнөговь	Үгүй	Тийм	Үгүй
15	Сүхбаатар	Тийм	Тийм	Үгүй

¹⁸ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

¹⁹ Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагыг оролцуулан улсын хэмжээнд аудит хийх



16	Сэлэнгэ	Тийм	Тийм	Үгүй
17	Төв	Үгүй	Тийм	Үгүй
18	Увс	Үгүй	Үгүй	Үгүй
19	Ховд	Үгүй	Үгүй	Үгүй
20	Хөвсгөл	Үгүй	Үгүй	Үгүй
21	Хэнтий	Тийм	Үгүй	Үгүй
22	Улаанбаатар	Үгүй	Тийм	Үгүй
	Дүн (хувиар)	50	59	0

Эх сурвалж: ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас хяналтын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж, баг, хорооны ИНХ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг огт хэрэгжүүлдэггүй байна.

с) ТЕЗ-ийн дотоод аудитын нэгжээс хяналт тавихтай холбоотой харилцааг журмаар зохицуулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, түүнчлэн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.5-д “Төсвийн ерөнхийлөн захирагч /дотоод аудитын алба/ нь шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” гэж тус тус заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт тавих харилцааг нарийвчлан зохицуулсан эрх зүйн зохицуулалтгүйгээс улс, орон нутгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжээс хуульд заасан хяналт шалгалт хийх чиг үүргээ харилцан адилгүй хэрэгжүүлж ажилласан байна.

Хяналт, шалгалт хийхдээ ШДНЦХ-т байршуулсан мэдээллийг холбогдох баримт материалтай тулган баталгаажуулж хяналт хийхгүй байгаагаас мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй зөрчил гарсаар байна.

Дээрх нөхцөл байдал болон хяналт тавих чиг үүрэг бүхий дотоод аудитын нэгжийн албан хаагчид хууль, холбогдох журмын талаар ойлголт, мэдээлэл харилцан адилгүй байгаагаас дотоод хяналт үр нөлөөгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд Шилэн дансны тухай хуульд дотоод хяналт тавихтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журам батлах, хэрэгжүүлэх талаар болон хяналт тавих давтамж, хугацаа болон дотоод хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Дараах аймгуудын Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд дор дурдсан арга хэмжээг авч, ажилласан байна.

- Говь-Алтай аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 23 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.
- Завхан аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 22 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.
- Өмнөговь аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2018 оны 1-3 дугаар улиралд хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн 11 сумын 75 байгууллага, төсвийн 7 байгууллага, нийт 82 байгууллагын дарга, эрхлэгч, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн.



- Увс аймгийн Санхүү, хяналт, аудитын алба 10 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.
- Говьсүмбэр Санхүүгийн хяналт, аудитын алба 14 байгууллагад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд ТЕЗ-д хяналтыг хэрэгжүүлэх хуулийн зохицуулалтгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэж заасан тул хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д тус тус заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт тавих талаарх зохицуулалт Шилэн дансны тухай хуульд тусгагдаагүй байна.

Санхүүгийн тайлан нэгтгэгддэг ТЕЗ болон ТӨБЗГ-аас хяналт тавих эрх зүйн зохицуулалтгүйгээс хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах хуулийн этгээдүүдэд дотоод хяналт хийж шаардлага тавьсан ч биелүүлэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1²⁰-д заасны дагуу Хөдөлмөрийн гэрээ, контракт байгуулан ажилладаг албан хаагчид Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллийг байршуулах үүрэг хүлээж байна.

Гэвч тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан тул Хөдөлмөрийн гэрээ, контрактаар ажилладаг албан хаагчдад хариуцлага тооцоход дээрх хуулийн заалтыг баримтлах боломжгүй тул гэрээнд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн хэсгийг нэмж тусгах шаардлагатай байна.

Иймд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д ААНБ, хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт тавих этгээдийг оновчтой тодорхойлж, хүлээлгэх хариуцлагын талаар Шилэн дансны тухай хуульд тусгах шаардлагатай.

3.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцаж, мэдээлэл нь ойлгомжтой, ач холбогдолтой байгаа эсэх

“Нээлттэй нийгэм форум” ТББ нь гэрээний дагуу аудитын хугацаанд ШДНЦХ-т байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцаж, хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхэд судалгаа, дүн шинжилгээ хийж “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааны тайлан” ирүүлснийг хавсаргав. /Хавсралт №3/

20 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

3.1.3.хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

3.1.4.улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;

3.1.5.төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.



Тус байгууллагаас иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран шилэн дансны нэгдсэн цахим хуудасны хэрэглэгчийн санал асуулгын судалгааг зохион байгуулж нийслэлийн 3 дүүргийн 600 гаруй иргэнийг хамруулсан.

Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн иргэдийн дунд хийсэн энэхүү судалгааны дүнгээр ШДНЦХ-ны талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь харагдав. Тухайлбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 55% нь шилэн дансыг “бага зэрэг мэднэ”, гэж хариулсан бол зөвхөн 8% нь “сайн мэднэ” гэжээ. Цаашилбал, Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар иргэдийн 32.5% нь “бага зэрэг мэднэ”, гэсэн бол зөвхөн 6% нь “сайн мэднэ” гэжээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн зөвхөн 6% нь улс, орон нутгийн болон төсвийн байгууллагын төсвийн талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаснаас авдаг байна.

ШДНЦХ-наас мэдээлэл авдаг иргэд мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал, ойлгомжтой, ач холбогдолтой байдал, тогтоосон хугацаандаа мэдээлдэг байдал болон хуулийн дагуу нууцад хамруулснаас бусад бүх мэдээллийг нээлттэй байршуулж буй байдалд “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 1.6% нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, зөрчлийн талаар гомдол болон шаардлага гаргасан байна.

Судалгааны дүнгээс харахад, төсвийн удирдлагад олон нийт хяналт тавих үйл ажиллагааг дээшлүүлэхийн тулд Шилэн дансны тухай хууль болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг иргэдэд таниулах ажлыг төр засгийн зүгээс хийх шаардлагатай байна. Мөн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн ойлгомжтой байдлыг дээшлүүлэх, мэдээллээ шинэчилж, татаж авахад хялбар болгох шаардлагатай гэсэн нэгдсэн дүгнэлтийг гаргасан.

3.4. Өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт 43.7 хувь байна.

Төрийн аудитын байгууллагаас 2017 онд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд тухай бүр залруулга хийлгэж ажилласнаас гадна нийт 72 байгууллагад хариуцлага тооцуулах, 415 зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн хэрэгжсэн байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг хүснэгт 11-д үзүүлбэл:

Хүснэгт-11:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдал

№	Төрийн аудитын байгууллага	Нийт зөвлөмжийн тоо	Зөвлөмжийн хэрэгжилт		
			Хэрэгжсэн	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй
1	Архангай аймаг дахь ТАГ	4	1	3	0
2	Баян-Өлгий аймаг дахь ТАГ	0	0	0	0
3	Баянхонгор аймаг дахь ТАГ	3	3	0	0
4	Булган аймаг дахь ТАГ	4	3	1	0
5	Говь-Алтай аймаг дахь ТАГ	2	2	0	0
6	Говьсүмбэр аймаг дахь ТАГ	6	5	0	1
7	Дархан-Уул аймаг дахь ТАГ	3	2	0	1
8	Дорноговь аймаг дахь ТАГ	2	2	0	0
9	Дорнод аймаг дахь ТАГ	3	2	0	1



10	Дундговь аймаг дахь ТАГ	4	1	1	2
11	Завхан аймаг дахь ТАГ	4	0	0	4
12	Орхон аймаг дахь ТАГ	4	0	4	0
13	Өвөрхангай аймаг дахь ТАГ	4	2	2	0
14	Өмнөговь аймаг дахь ТАГ	1	1	0	0
15	Сүхбаатар аймаг дахь ТАГ	3	1	2	0
16	Сэлэнгэ аймаг дахь ТАГ	6	1	5	0
17	Төв аймаг дахь ТАГ	3	1	0	2
18	Увс аймаг дахь ТАГ	6	4	0	2
19	Ховд аймаг дахь ТАГ	3	0	0	3
20	Хөвсгөл аймаг дахь ТАГ	7	4	0	3
21	Хэнтий аймаг дахь ТАГ	4	2	2	0
22	Нийслэл аймаг дахь ТАГ	6	1	3	2
23	Үндэсний аудитын газар	5	0	3	2
Дүн (хувиар)		100	43.7	29.9	26.4

Эх сурвалж: ШДНЦХ, ТЕЗ-даас 2018 оны 3-р улирлын байдлаар ирүүлсэн мэдээ.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийг Төсвийн тухай хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан хуульчлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг Шилэн дансны тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, тайланд дурдагдсан журамлах шаардлагатай асуудлуудыг судалж шийдвэрлэх зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн.

Дээрх зөвлөмжийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар Шилэн дансны тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Харин Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуй нэгж, байгууллагуудтай байгуулах гэрээнд ШДНЦХ-т хуульд заасан мэдээллийг байршуулах үүргийг тусгаж, биелэлтээр санхүүжилт олгох арга хэмжээ авах зөвлөмж хэрэгжээгүй байна.

Сангийн сайдад ТЕЗ-ийн дотоод аудитын албыг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих арга зүйн удирдлагаар хангаж ажиллах зөвлөмж өгсөн бөгөөд тус зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

Харин ШДНЦХ-т хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т хамаарах татан буугдсан, давхар цэс үүсгэгдсэн, 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д хамаарах үйл ажиллагаа явуулдаг эсэх нь тодорхойгүй ААНБ-ын цэсийг цэгцлэх зөвлөмж өгсөн. Сангийн яамнаас дээрх зөвлөмжийн дагуу Шилэн данс хөтлөөгүй байгууллагуудын жагсаалтыг хянан хариу ирүүлэх талаар ТЕЗ нарт системийн дотоод захиагаар хүргүүлсэн боловч үр дүн гараагүй байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа хэвшил болгоогүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтан гарсаар байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах улсын төсвийн ТЕЗ-ийн харъяа 869 байгууллагын хуулийн хэрэгжилт 86.7 хувь, Аймаг, нийслэлийн төсвийн ТЕЗ-ийн харъяа 4079 байгууллагын хуулийн хэрэгжилт 86.2 хувьтай байна.
2. Хуульд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн мэдээлээгүй зөрчлийг гаргаж төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаагүй 519 байгууллагад зөрчил арилгуулах, холбогдох 48 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг тус тус өгсөн.
3. Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөр болон Засгийн газрын тусгай сангийн төсөв зарцуулах үйл ажиллагааг ил тод мэдээлэх талаар хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.
4. Шилэн дансны тухай хууль, холбогдох журамд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах мэдээллийн нийтлэг стандартыг тогтоогоогүйгээс Аймаг, нийслэл дэх ТЕЗ-ийн харъяа байгууллагууд мэдээллийн самбартаа хуульд заасан мэдээллийг байршуулаагүй зөрчил байна.
5. Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны боловсруулалт, хөгжүүлэлт хангалтгүйгээс www.tender.gov.mn сайтад мэдээллийг давхардуулж байршуулдаг, мэдээлэл байршуулах цэс бусад төсөв, санхүүгийн төлөвлөх, тайлагнах загвар маягтуудтай уялдаагүйгээс мэдээллийг гараар шивж оруулдаг зэргээр ажлын хэт ачаалал үүсгэдэг, байгууллагуудын хөтөлж байгаа цэс нь зөрүүтэй үүсгэгдсэн зэрэг зөрчилтэйгөөс хуулийн 4 дүгээр зүйлд заасан *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ач холбогдолтой байх”* зарчмын хэрэгжилт хангалтгүй байна.
6. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д хамаарах арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгчид хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй нь санхүүжилт олгосон байгууллагаас хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зохицуулалтгүйтэй холбоотой байх тул уг асуудлыг хууль, журамд нэмж зохицуулах шаардлагатай байна.
7. Хуулийн хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгдсэн арга зүйн зохицуулалтгүй, дотоод аудитын нэгжийн албан хаагчид хууль, холбогдох журмын талаар харилцан адилгүй ойлголт, мэдээлэлтэйгээс дотоод хяналт үр нөлөөгүй байна.
8. Хуулийн хэрэгжилтэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын хөндлөнгийн хяналтын чиг үүрэг хангалтгүй, баг, хорооны ИНХ-аас хөндлөнгийн хяналтыг огт хэрэгжүүлдэггүй байна.
9. Иргэд, олон нийт 2018 онд 3 дугаар улирлын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 324,578 удаагийн хандалтаар 2,675,397 мэдээлэлтэй танилцаж, байгууллагуудын мэдээлэл байршуулах чиг үүрэх бүхий албан хаагчид 413,183 удаагийн хандалт хийж холбогдох мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан байна.
10. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд өмнөх аудитуудаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн хэдий ч зөвлөмжийн биелэлт 43.7 хувь байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх танаа:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 154 дүгээр захирамжаар байгуулагдсан “Шилэн дансны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах” чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлж, Төрийн аудитын байгууллагаас өмнөх онуудад хийгдсэн 5 удаа нийцлийн аудитын тайлан тус бүрд зөрчилд дурдсан асуудлыг хуулийн төсөл боловсруулахад анхаарах;
2. Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлд заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагад нийцүүлж, 2017 оны аудитын тайланд тусгасан журмын зөрчлийг арилгах, энэхүү аудитаар өгсөн дүгнэлт зөвлөмжийг харгалзан шинэчлэн боловсруулах арга хэмжээ авах;
3. Энэхүү тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрийн төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хууль, тогтоомжтой уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;
4. Мөн тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Засгийн газрын тусгай сангуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хуультай уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;
5. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулахдаа Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх үүргийн талаар тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэдэг байх талаар холбогдох арга хэмжээ авах;
6. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг оновчтой тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах талаар арга хэмжээ авах зэрэг болно.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танаа:

1. Энэхүү тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл хэлбэрээр санхүүждэг зарим томоохон төсөл, хөтөлбөрийн төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хууль, тогтоомжтой уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;
2. Мөн тайланд зөрчилтэй асуудлыг дурдсан Засгийн газрын тусгай сангуудын төсөв санхүүгийн үйл ажиллагааг ил тод мэдээлэх зохицуулалтыг Шилэн дансны тухай хуультай уялдуулах талаар холбогдох арга хэмжээ авах;
3. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулахдаа Шилэн дансны тухай хуулийг



- хэрэгжүүлэх үүргийн талаар тусгаж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэдэг байх талаар холбогдох арга хэмжээ авах;
4. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д хамаарах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах цэс үүсгүүлж, мэдээлэл оруулах этгээдийг оновчтой тодорхойлж, үүрэгжүүлэх;
 5. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д хамаарах хуулийн этгээдүүдийн шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавих этгээдийг оновчтой тодорхойлж; хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах талаар арга хэмжээ авах;
 6. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг эрхлэн хөтлөх чиг үүргийн хүрээнд цахим хуудасны агуулга стандартыг хууль, журамд нийцүүлэн, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсөв, санхүү, худалдан авах ажиллагаанд ашигладаг бусад систем, программтай уялдуулан мэдээллийг шууд хөрвүүлж хялбаршуулсан байдлаар ил тод мэдээлэхээр шинэчлэн хөгжүүлэх арга хэмжээ авах;
 7. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу баг, хороодын иргэдийн Нийтийн Хурлын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгож, холбогдох сургалт зохион байгуулах;
 8. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар хуулийн хэрэгжилтэд ТЕЗ-ийн дотоод болон хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхээр системийн хөгжүүлэлтийг сайжруулах талаар арга хэмжээ авах;
 9. Төсвийн Ерөнхийлөн Захирагчдын дотоод аудитын нэгж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл оруулах эрх бүхий албан хаагчдад Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах.

--- ОоО---